



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А-278

Улаанбаатар хот

Хэрэглээний зээлд хугацааны хязгаарлалт тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8. дахь заалт, 22¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монголбанкны Мөнгөний бодлогын Хорооны 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэнд шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн нийт хугацааг 30 сараас дээшгүй байхаар тогтоосугай.

2.Энэ тушаалын 1-т заасан “хэрэглээний зээл”, “зээлийн нөхцөлийг нь өөрчлөх” гэснийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А-277 дүгээр тушаалаар батлагдсан “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ын 1.2-1.5 дугаар заалтын дагуу тодорхойлсугай.

3.Энэ тушаалын 1 дэх заалт нь картын хүчинтэй хугацаанд хамаарахгүйгээр тогтоосугай.

4.Энэ тушаалыг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

5.Энэ тушаалыг зээлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкны Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

6.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Судалгаа, статистикийн газар (Д.Даваасүх), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-г тус тус үүрэг болгосугай.

7.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-234, 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А-51 дүгээр тушаалуудыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 1563